

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2024/134-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2024 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор:

Г. Даваа

Утас:

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер:

М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор:

Л.Оюунбилэг

Утас: 99206951

Цахим хаяг: auditor1@mundig.mn

Миндүг аудит ХХК-ийн захирал: С.Энхтөр

Утас: 95957791

Цахим хаяг: director@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	10
3.2 Зөвлөмж	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН
СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ЭНХСАЙХАН ТАНАА

ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤ ᠠᠶᠢᠮᠦᠨ
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ
№ 150
танай _____ - ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа, тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус асуудал үүсээгүй, сургалт явуулахтай холбоотой хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

2023 онд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 40.0 сая төгрөг, төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,445.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,314.5 сая төгрөг буюу 90.9 хувийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 131.1 сая төгрөгийг тайланд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус сургуулийн 1-5 дугаар ангийн суралцагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд өдрөөр гаргасан гүйцэтгэлийн зөрүүгээс үүссэн төсвийн хэмнэлтээс 1.0 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлж, 13.5 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэлгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 7 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг төлөвлөж 89.2%-тай биелэгдсэн. 2023 онд Цахим кабинет: Eduten, Pearson хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд сумын нөхөн хангалтын зардлаас 35.8 сая төгрөг зарцуулж бага болон дунд оврын chromebook, таблет, багшийн болон сурагчийн ширээ сандал худалдан авч цахим кабинетыг байгуулан ашиглалтад оруулсан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 18 зөөврийн компьютероор хангагдсаны үр дүнд багш нар цахим хичээл боловсруулах, шинэ программ, апп-ыг сурталтандаа ашиглах боломж бүрдсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	134,504,910.71	232,032,247.79
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	39,999,823.30	131,055,639.18
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	39,999,823.30	131,055,639.18
3121	Төгрөг	39,999,823.30	131,055,639.18
31211	Төрийн сангийн харилцах	39,999,823.30	131,055,639.18
33	АВЛАГА	-	6,821,375.00
335	Бусад авлага	-	6,821,375.00
3351	Байгууллагаас авах авлага	-	6,821,375.00
35	БАРАА МАТЕРИАЛ	94,505,087.41	94,155,233.61
351	Түүхий эд материал	-	420,500.00
35110	Тусгай зориулалттай материал	-	420,500.00
354	Хангамжийн материал	87,705,087.41	93,734,733.61
35410	Бичиг хэргийн материал	-	370,000.00
35450	Барилгын засварын материал	120,000.00	120,000.00
35460	Хүнсний материал	-	320,000.00
35470	Бусад хангамжийн материал	87,585,087.41	92,924,733.61
35600	Мал амьтад	6,800,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,226,133,900.20	2,239,756,655.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,226,133,900.20	2,239,756,655.37
392	Биет хөрөнгө	2,185,235,900.20	2,199,482,145.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,281,969,158.80	2,281,969,158.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(280,657,460.44)	(361,378,957.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,500,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,500,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	146,381,922.00	277,101,628.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(71,110,556.22)	(95,984,416.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	107,971,300.00	115,991,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,458,843.31)	(47,451,437.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	105,594,700.00	105,594,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(103,844,300.44)	(104,194,300.48)
39217	Ном	27,389,979.81	27,435,979.81
393	Биет бус хөрөнгө	40,898,000.00	40,673,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(50,000.00)	(275,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,448,000.00	39,448,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,360,638,810.91	2,472,187,393.16
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	1,990,500.00	26,537,687.55
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,990,500.00	26,537,687.55
413	Өглөг	1,990,500.00	26,537,687.55
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,450,481.55
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,990,500.00	-
4136	Бусад өглөг	-	25,087,206.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	25,087,206.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,358,648,310.91	2,445,649,705.61
51	Засгийн газрын хувь оролцоо	2,358,648,310.91	2,445,649,705.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	449,054,291.40	449,054,291.40
51101	Өмч: - төрийн	449,054,291.40	449,054,291.40
512	Хуримтлагдсан үр дүн	1,372,207,117.16	1,459,208,511.86
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,042,859,326.75)	1,372,207,117.16
51220	Тайлант үеийн үр дүн	2,415,066,443.91	87,001,394.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	537,386,902.35	537,386,902.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,360,638,810.91	2,472,187,393.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,317,943,823.48	1,533,208,386.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,865,666.48	87,610,786.20
120	Нийтлэг татварын бус орлого	115,865,666.48	87,610,786.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,865,666.48	87,610,786.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,312,100.00	1,986,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	1,568,750.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	113,553,566.48	80,706,190.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	-	3,349,246.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,202,078,157.00	1,445,597,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	955,845,500.00	1,274,991,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	955,845,500.00	1,274,991,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	2,550,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,700,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	233,982,657.00	170,606,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	233,982,657.00	170,606,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,200,603,098.02	1,446,206,991.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,200,603,098.02	1,446,206,991.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,131,330,750.02	1,367,454,312.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,040,243.70	882,600,621.54
210101	Үндсэн цалин	475,521,832.94	607,199,117.49
210102	Нэмэгдэл	165,527,576.76	236,225,545.10
210104	Урамшуулал	41,990,834.00	39,175,958.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,274,300.00	98,371,209.13
210201	Тэтгэврийн даатгал	65,466,500.00	67,373,955.36
210202	Тэтгэмжийн даатгал	7,702,000.00	7,755,485.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,161,600.00	6,182,261.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,540,400.00	1,548,036.35
210205	Эрүүл мэндийн даатгал	15,403,800.00	15,511,470.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,415,478.00	136,386,160.71
210301	Гэрэл, цахилгаан	10,100,328.31	13,801,479.71
210302	Түлш, халаалт	124,815,349.69	120,800,681.00
210303	Цэвэр, бохир ус	499,800.00	1,784,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,300.00	-
210402	Тээвэр, шатахуун	75,300.00	-
2105	Нормативт зардал	42,913,428.00	63,335,290.00
210502	Хоол, хүнс	42,913,428.00	63,335,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,426,359.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	4,426,359.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	5,114,600.00	8,136,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,312,100.00	1,986,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,802,500.00	6,149,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,071,041.32	168,625,030.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,574,441.50	31,259,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,085,700.00	12,202,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,410,899.82	125,162,950.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,272,348.00	78,752,679.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,272,348.00	61,354,115.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,274,748.00	61,354,115.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,997,600.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	17,398,564.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,398,564.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	117,340,725.46	87,001,394.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	32,695,400.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	32,695,400.00	-

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(32,695,400.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	84,645,325.46	87,001,394.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,204,390,257.00	1,447,584,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,312,100.00	1,986,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,312,100.00	1,986,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,312,100.00	1,986,600.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,312,100.00	1,986,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,202,078,157.00	1,445,597,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	955,845,500.00	1,274,991,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	955,845,500.00	1,274,991,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,550,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,700,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	233,982,657.00	170,606,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	233,982,657.00	170,606,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,146,443,852.70	1,299,619,128.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,146,443,852.70	1,299,619,128.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,073,914,632.70	1,220,445,948.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,352,513.70	882,600,621.54
210101	Үндсэн цалин	475,834,102.94	607,199,117.49
210102	Нэмэгдэл	165,527,576.76	236,225,545.10
210104	Урамшуулал	41,990,834.00	39,175,958.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,274,300.00	96,920,727.58
210201	Тэтгэврийн даатгал	65,466,500.00	65,923,473.81
210202	Тэтгэмжийн даатгал	7,702,000.00	7,755,485.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,161,600.00	6,182,261.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,540,400.00	1,548,036.35
210205	Эрүүл мэндийн даатгал	15,403,800.00	15,511,470.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,467,341.00	143,207,535.71
210301	Гэрэл, цахилгаан	10,100,328.31	13,801,479.71
210302	Түлш, халаалт	180,867,212.69	127,622,056.00
210303	Цэвэр, бохир ус	499,800.00	1,784,000.00
2105	Нормативт зардал	39,615,700.00	63,655,290.00
210502	Хоол, хүнс	39,615,700.00	63,655,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,546,359.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	4,546,359.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,502,500.00	10,126,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,312,100.00	1,986,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,190,400.00	8,139,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,155,919.00	13,935,274.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,070,219.00	1,725,474.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,085,700.00	12,209,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,529,220.00	79,173,179.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,529,220.00	61,774,615.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,531,620.00	61,774,615.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,997,600.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	17,398,564.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,398,564.29

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	57,946,404.30	147,965,071.88
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,946,581.00	58,478,006.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,946,581.00	58,478,006.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,946,581.00	58,478,006.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,946,581.00	58,478,006.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(17,946,581.00)	(58,478,006.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	39,999,823.30	89,487,065.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	39,999,823.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,999,823.30	131,055,639.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,266,087,230.99	-	2,252,528,424.74
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,266,087,230.99	-	2,252,528,424.74
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	84,645,325.46	-	84,645,325.46
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,350,732,556.45	-	2,337,173,750.20
D01	2023 ны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,372,207,117.16	-	2,358,648,310.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,372,207,117.16	-	2,358,648,310.91
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	87,001,394.70	-	87,001,394.70
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,459,208,511.86	-	2,445,649,705.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,489,547,800.00	1,338,711,969.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,489,547,800.00	1,338,711,969.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,419,646,300.00	1,276,937,354.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	978,887,500.00	882,600,621.54
210101	Үндсэн цалин	667,481,600.00	607,199,117.49
210102	Нэмэгдэл	272,248,100.00	236,225,545.10
210104	Урамшуулал	39,157,800.00	39,175,958.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,360,800.00	96,920,727.58
210201	Тэтгэврийн даатгал	83,205,400.00	65,923,473.81
210202	Тэтгэмжийн даатгал	9,788,800.00	7,755,485.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,831,200.00	6,182,261.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,957,700.00	1,548,036.35
210205	Эрүүл мэндийн даатгал	19,577,700.00	15,511,470.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,606,100.00	143,207,535.71
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	13,801,479.71
210302	Түлш, халаалт	144,106,100.00	127,622,056.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	1,784,000.00
2105	Нормативт зардал	64,856,900.00	63,655,290.00
210502	Хоол, хүнс	64,856,900.00	63,655,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,521,300.00	8,139,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,381,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,139,900.00	8,139,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,413,700.00	72,413,280.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,203,900.00	60,203,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,209,800.00	12,209,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,901,500.00	61,774,615.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,901,500.00	61,774,615.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,901,500.00	61,774,615.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,448,545,400.00	1,447,166,350.00
1320	ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,448,545,400.00	1,447,166,350.00
122005	Орон нутгийн төсвөөс	170,606,000.00	170,606,000.00
	Улсын төсвөөс санхүүжих	1,274,991,500.00	1,274,991,500.00
	Үйл ажиллагааны орлогоос		1,568,850.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		39,999,823.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		131,055,639.18

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16.4 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 14.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1.4 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 16.4 төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5.3 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

Тус сургуулийн 1-5 дугаар ангийн суралцагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд өдрөөр гарсан гүйцэтгэлийн зөрүүгээс үүссэн төсвийн хэмнэлтээс 13.5 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэлгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*”, Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 “*Энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно*”, гэсэн заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

3.2 Зөвлөмж

1. Орон тоо цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бүтэц орон тоогоор батлагдаагүй мэдээлэл технологийн ажлыг архив бичиг хэргийн ажилтанд хавсруулж сар бүр 10%, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан ажлыг нярав, сургалтын менежер нарт хариуцуулж ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг хагас жил тутамд 40%-аар тооцож 1.4 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д заасан “байгууллагын бүтэц чиг үүргийг оновчтой тодорхойлж цалин хөлсийг орлого үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Төсвийн төслөө батлуулахдаа шаардлагатай орон тоогоо зөв төлөвлөж, цалингийн сан батлагдсан тохиолдолд ажил хавсруулах нэмэгдлийг олгох. Орон тоо нь батлагдаагүй ажлын байранд ажил хавсран гүйцэтгүүлэх тушаал гаргахгүй, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулан тухайн ажил үүргийг гүйцэтгүүлэхэд анхаарах

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд тайлант онд 159 мэдээлэл байршуулахаас 155 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг байршуулаагүй, мөн өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан захирлын тушаал шийдвэр, байгууллага иргэнтэй байгуулсан гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.3.3-д “төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол шалтгааныг тайлбарлах” 8.4-д “Байгууллага албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг ил тод, үнэн зөв, иж бүрэн хугацаанд нь байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үдийн хоолны төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй	1	13,501.4	1	13,501.4								
Бүтэц орон тоо батлагдаагүй ажлын байранд хавсран ажилласны нэмэгдэл олгосон	1	1,447.1					1	1,447.2				
Дүн	1	14,948.5	1	13,501.4			1	1,447.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
5 мэдээлэл хугацаа хоцроож, 5 мэдээлэл байршуулаагүй, хөрөн мөнгөтэй холбоотой тушаал шийдвэрийг байршуулаагүй	1				1	
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						